



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37, 29 дүгээр хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18072

Утас: 7018 1208, 7018 1447, 7018 1206,

Цахим шуудан: info@ngs.gov.mn,

Цахим хуудас: www.ngs.gov.mn

2025.12.18 № 1/904

танай _____-ны № _____-г

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР
З.БААСАННЯМ ТАНАА**

Үндэсний геологийн албаны 2025 оны Авлигын эсрэг, шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу

Хавсралт... хуудастай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ

Н.МӨНХБИЛЭГ



D:\My WORKS\TS work\Alban bichig tuluvluh\ATT

182505 00898

Үндэсний геологийн албаны 12 дугаар
сарын 18-ны өдрийн 11902 тоот албан
бичгийн хавсралт

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ, ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	2	3	4	5	6
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1	1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	Тухай бүр	Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	А/ байгууллагын албан ёсны цахим хуудаст улиралд 5-аас дээш контентыг түгээсэн байх. Б/мэдээлэл сурталчилгааны самбарыг улирал бүр шинэчилж ном, гарын авлагыг байршуулах.	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентууд шторк, 110 подкаст, Монголын радио-той хамтран бэлтгэсэн цуврал, нэвтрүүлэг зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас ngs.gov.mn-д байршуулан ажиллав. Авлигатай тэмцэх газраас гаргасан бусад төрлийн хэлбэрээр сурталчилж байгаа Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 14, 17, 18, 11, 21 дэх хэсгүүдтэй холбоотой сурталчилгааны брошур мэдээллийг байгууллагын бүх албан хаагчид болон геологи судалгааны төсөл хэрэгжүүлж буй 14 аж ахуй нэгжид тараах, байгууллагын мэдээллийг самбарт байршуулах, дотоодын сүлжээнд авлигын эсрэг журмын шинэчлэл зэргийг байршуулж соён гэгээрүүлэх мэдээллийг олон нийтэд сурталчилах ажлыг гүйцэтгэв.
2	1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы	III улиралд	- Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа,	А/ нээлттэй хаалганы өдрөөр авлигын эсрэг зурагт хуудас, ном	2025 оны 09 дүгээр сарын 11-13-ны өдөр зохион байгуулагдсан "Mining Week" арга хэмжээний үеэр иргэд, ААН, хөрөнгө оруулагчдад зориулж геологийн албаны үйл ажиллагааг сурталчилах

	өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах		үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	гарын авлагыг суртачлах, өөрийн байгууллагын хууль дүрэм, ил тод байдлыг иргэдэд тайлбарлаж өгөх арга хэмжээ зохиох. Б/ оролцсон иргэдээс санал, хүсэлт, гомдлыг бүртгэн авах 50-аас дээш иргэд оролцсон байх.	ажлыг зохион байгуулав. Албаны бүх албан хаагчид оролцож, сонирхсон эдгээдэд үйл ажиллагааны мэдээллийг танилцуулсан. Энэ үеэр ҮГА-ны зүгээс 4 илтгэл бэлтгэж хэлэлцүүлсэн. ҮГА-ны чиг үүргийн хүрээнд иргэд аж ахуйн нэгжид үзүүлж буй голлох 3 үйлчилгээ: • Геологийн баримтын төв архиваас иргэд ААН-д үзүүлэх үйлчилгээ • Геомэдээллийн төвөөс иргэд ААН, төрийн байгууллагад үзүүлэх үйлчилгээ • Хилээр дээж нэвтрүүлэх зөвшөөрөл олгох үйлчилгээ Эдгээр үйл ажиллагааны үе шат дараалал, эрх зүйн мэдээллийн талаар танилцуулга боршур бэлтгэж 100 хувийг арга хэмжээний үеэр тараах, байгууллагын вэб сайт, ил тодын цахим хуудаст байршуулах ажлыг гүйцэтгэв. Мөн арга хэмжээний үеэр салбарын авлигын эрсдлийн судалгааг нийт 550 оролцогчоос авсан.
3	1.3 Иргэдэд зориулсан өөрийн салбартай холбогдох цахим ном гарын авлага бүтээх, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл, 110 дугаарыг сурталчлах.	I-IV улиралд	- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;	Үзэлт 2000-аас дээш байх.	Үндэсний геологийн албаны иргэдэд чиглэсэн үйлчилгээ болох Геологийн баримтын төв архиваас иргэд ААН-д үзүүлэх үйлчилгээ, Гео-мэдээллийн төвөөс иргэд ААН, төрийн байгууллагад үзүүлэх үйлчилгээ, Хилээр дээж нэвтрүүлэх зөвшөөрөлүүдийн талаар танилцуулга, үйлчилгээг авахад ашиглагддаг журам зааврыг оруулсан танилцуулга брошурыг хэвлэлтэд өгсөн. Төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан "Геологийн баримтын төв архиваас хэрхэн үйлчилгээ авах вэ" нэртэй брошур 1000 хувь хэвлэгдэж тараах ажлыг гүйцэтгэж байна. Иргэдэд чиглэсэн 3 төрлийн төрийн үйлчилгээг хэрхэн авах тухай мэдээллийг байгууллагын вэб

			- Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.		сайт, ил тодын цахим хуудаст байршуулан ажиллаж байна. Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд холбогдох нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт 6-н журмыг Захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүрэн бүртгүүлж, байгууллагын вэб хуудаст байршуулан ажиллав. Байгууллагын Авлигын эсрэг хамтдаа самбарт "Шүгэл үлээгчийн эрх зүйн талаар, шүгэл үлээгчийн хамгаалалтын талаар мэдээллийг бэлтгэж байршуулсан. Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг 2025 онд батлагдах байгууллагын дотоод журмын байгууллагын үүрэгт тусгаж ажиллав. Авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан зурагт хуудсыг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.
4	1.4 Өөрийн байгууллагын үйл ажиллагаа, авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан видео, контент бүтээх.	I-IV улиралд	- Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.	А/Үзэлт 2000-аас дээш байх. Б/ 4-өөс доошгүй байх	Үндэсний геологийн албаны үйл ажиллагааг танилцуулж, авлигын хор хөнөөл, 110 тусгай дугаарыг сурталчилсан Анимэйшн 3D хэлбэртэй 1 минут 30 секунтийн шторк бэлтгэж байгууллагын вэб сайтад байршуулан ажиллав. https://youtu.be/PqL2aAmTZbM?t=1 АҮЭБЯам, Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран Авилга бол чимээгүй тахал нэртэй шторк бэлтгэж, байгууллагын вэб сайтад байршуулсан. https://youtu.be/PqL2aAmTZbM
2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					
5	2.1 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд	I-IV улиралд	- Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж	Жилд хамгийн багадаа 1	Institute of Public Monitoring нэртэй судалгааны байгууллагатай хамтран Аж үйлдвэр эрдэс

	иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх		буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх	байгууллагатай хамтран ажилласан байх.	баялгийн салбарын авлигын эрсдлийн судалгааг хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаа нь "Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын авлигын эрсдэлийн төсөөллийг судалгааг олон талын оролцоотойгоор боловсруулахад чиглэсэн бөгөөд нийт 18 хоногийн хугацаанд иргэн, хувийн хэвшил/хуулийн этгээд/, олон улсын байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл буюу төрийн бус байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, бусад(хуульч, өмгөөлөгч, судлаач) гэсэн бүлгүүдийн төлөөлөл 550 оролцогчоос тухайн судалгааг авсан болно. Тус судалгаа нь аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хамаарах голлох үйлдвэрлэл, эрдэс баялаг түүхий эдийн төрлөөс хамааран авлига үүсэх эрсдэл, тус салбарт холбогдох төрийн үйлчилгээ, албан хаагч, оролцогчдын үйл ажиллагаанд хаана авлигын эрсдэл үүсэх боломжтой гэж үзэж байгааг илрүүлэн эрсдэлийн түвшинг үнэлэх хэлбэрээр аж үйлдвэр, эрдэс баялгийн салбар дахь авлига, ашиг сонирхлын авлигын төсөөллийг боловсруулсан. Энэхүү судалгаанд үндэслэн авлигын эрсдэл өндөртэй албан хаагчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа боловч санхүүжилтийг СЯ-наас АҮЭБЯ-д шилжүүлэх ажил удаашралтай байгаагаас хүлээгдэж байна.
6	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг өөрсдийн цахим хуудсанд байршуулах.	I-IV улиралд	Тус хуулийн 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.	Хууль журмын дагуу ил тод мэдээлсэн байх	Үндэсний геологийн албаны 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт,

					албан шаардлага, бусад мэдээлэл багтаж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна. Үүнд: -Төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан, -5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 46 гүйлгээний мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд ил тод нээлттэй мэдээлсэн. 2025 оны 12 сарын байдлаар нийт мэдээллэх 171 мэдээллээс 148 мэдээллийг оруулсан бөгөөд 135-ыг хугацаанд нь 13 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 23 мэдээллийн оруулах хугацаа болоогүй байна. Үндсэн үйл ажиллагааны нээлттэй мэдээллүүдийг улирал тутамд shilen.gov.mn сайтад 18 төрлийн тайланг цахимаар илгээж үнэлүүлсэн. Эхний улирал 96.3%, хагас жил 97.13%, 3 дугаар улирал 100% үнэлүүлсэн. Жилийн эцсийн тайлан илгээх хугацаа болоогүй байна. Хүний нөөцийн нээлттэй мэдээллүүдийг улирал тутамд shilen.gov.mn сайтад хүний нөөцийн нээлттэй мэдээллүүдийн 7 төрлийн тайланг цахимаар илгээж үнэлүүлсэн. Эхний улирал 88.1%, хагас жил 92.6%, 3 дугаар улирал 85,71% үнэлүүлсэн. Жилийн эцсийн тайлан илгээх хугацаа болоогүй байна Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх нээлттэй мэдээллүүдийг улирал тутамд shilen.gov.mn сайтад 15 төрлийн тайланг цахимаар илгээж үнэлүүлсэн. Эхний улирал 100%, хагас жил 95,51%, 3 дугаар улирал 97,76% үнэлүүлсэн. Жилийн эцсийн тайлан илгээх хугацаа болоогүй байна
--	--	--	--	--	---

7	Байгууллагын цахим хуудсанд өөрчлөлт хийж иргэдийг мэдээлэл хайх, санал хүсэлт өгөхөд амар хялбар байдлаар өөрчлөх.	I-IV улиралд	Төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна	Цахим хуудсанд сайжруулалт хийсэн байх.	https://ngs.gov.mn/ цахим хуудаст иргэдийг мэдээлэл хайх, амар хялбар байх, иргэдээс мэдээлэл авах хаяг, майлийг нээлттэй байршуулан ажиллаж байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Хилээр геологи судалгааны дээж нэвтрүүлэх зөвшөөрөл болон орд илрэлийн давхцалын лавлагаа олгох үйлчилгээнүүдийг e.business.mn системд оруулан цахимжуулах ажлыг зохион байгуулахаар 2025-11-25 өдрийн 1/834 дугаартай албан хүсэлтийг хүргүүлэн, холбогдох зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж эхлээд байна.
8	Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	I-IV улиралд	Ирсэн гомдлыг нэгтгэн дүгнэж тайлагнасан байх.	-Гомдлын агуулгыг багцлан ялгаж үр дүнтэй ямар арга хэмжээ хэрэгжүүлж хаасан талаар улирал бүр гаргах.	2023 оноос 2025 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар Үндэсний геологийн албанд 102 өргөдөл ирсэн байна. Үүнээс 67 өргөдлийг хугацаанд нь, 35 өргөдлийг хугацаа хоцорч, байгууллагын хэмжээнд өргөдөл хүсэлтийг 100% шийдвэрлэсэн төлөвтэй байна. Өргөдлийн дийлэнх хувь буюу 99 хувийг хөдөлмөрийн эрхлэх харилцааны чиглэлээр буюу чөлөө авах, ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх зэрэг хүсэлт өргөдөл эзэлж байгаа ба байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн гомдол ирээгүй болно. 11-11 цахим мэдээллийг системд 2025 онд аливаа гомдол хүсэлт бүртгэгдээгүй болно. 2025 оны 09 дүгээр сард Геофизикийн зөвлөх инженер Н.Баатрын гаргасан Геологи, Уул Уурхай, Хүнд Үйлдвэр, Газрын Тосны салбарт тулгамдсан асуудлын тухай 1 санал бүртгэгдсэн.
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
9	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос	I-IV улиралд	Хяналт чанаржсан байна.	A/ Дотоод хяналтын үйл ажиллагааг	Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт хийх журам"-ын 3.2-т "Байгууллага нь хяналт-

	ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;			сайжруулж хэлтэс, алба бүрт дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах. Б/ Илэрсэн зөрчил алдаа дутагдлыг авлигатай тэмцэх газарт тайлагнах	шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг)-тай байх бөгөөд хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг) нь зохион байгуулалтын хувьд бусад нэгжээс хараат бусаар үйл ажиллагаа явуулна.” гэж заасан. Гэвч ҮГА-ны хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан 1 мэргэжилтэнтэй байсан ба тус мэргэжилтэн нь ТЗУХ-т харъяалагдаж байсан нь “Хяналт хийх журам”-ын 2.1.1-д шударга, хараат бус байх зарчим болон дээр дурдсан 3.2 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байсан. Ийнхүү 2025 оны 10 дугаар сард байгууллагын Стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг АҮЭБЯ-аар шинэчлэн батлуулахдаа хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгжтэй байхаар зохион байгуулалтын бүтцийг батлуулсан.
10	Өөрийн байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд шинэчлэл хийж авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	I-IV улиралд	-нийт мөрдөгдөж буй дүрэм журмын жагсаалтыг хүргүүлэх -өөрчлөлт оруулсан дүрэм журмыг хүргүүлэх	Мөрдөгдөж буй нийт дүрэм журмын жагсаалтыг авлигатай тэмцэх газар хүргүүлж, дүрэм журамд шинэчлэл өөрчлөлт хийж ажлын хэсэг байгуулж дүрэм журмыг шинэчлэн найруулах.	Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд холбогдох нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт мөрдөгдөж буй 6-н журмыг Захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүрэн бүртгүүлж, байгууллагын вэб хуудаст байршуулан ажиллав. Байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулах ажлыг хэсгийг байгуулж хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт хийж, төслийг 2025-09-08-ны өдөр байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах ажлыг гүйцэтгэв.
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
11	Байгууллагын албан хаагчдад иргэдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын цагийг баримтлах, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, иргэний гаргасан хүсэлтэд дурдсан асуудлыг	I-IV улиралд	Бүх албан хаагчдаар баталгаа гаргуулсан байх;	Албан хаагчдаас баталгаа гаргуулах,	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолоор ХАСХОМ-ийн маягт шинэчилсэнтэй холбогдуулан уг мэдүүлгийг нөхөх зааврыг Авлигатай тэмцэх

	бүрэн дүүрэн тайлбарлаж өгч байх, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ ах дүү, танил талынхаа нөлөөнд автахгүй байх, бусдад хууль бус давуу байдал олгохгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулахгүй байх, бусдаас шан харамж авахгүй байх, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхгүй байх, хувийн ашиг сонирхол гаргахгүй байх талаар баталгаа гаргуулах, эдгээр зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;		Албан хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх;	Сургалт зохион байгуулах	газрын даргын 2024 оны А/96 дугаар тушаалаар баталж, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын хэмжээнд 2025-01-07-ны өдөр 1 удаа бүх албан хаагчдад сургалт зохион байгуулав. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалтгалт дүн шинжилгээний хэлтсээс 2025-01-06-ны өдөр зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, ХАСУМ, ХАСХОМ Мэдүүлэг тайлбар гаргахтай холбоотой мэдээллийг байгууллагын хэмжээнд хүргэж, дотоод сургалтыг 1 удаа зохион байгуулав. 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр АТГ-ын ажилтан, комиссар С.Баярцэцэг, А.Тунамал-Эрдэнэ нар тус байгууллагад хүрэлцэн ирж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэглээ, хэрэгжилтийн талаар болон авлигын гэмт хэрэг зөрчлийн шинжтэй үйлдлийн талаар сургалтыг зохион байгуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос "Ёс зүй танаас эхлэнэ" нэртэй сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж төрийн үйлчилгээг ёс зүйтэйгээр үзүүлэх, албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэв.
12	Тухайн байгууллагаас иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний хугацаа, чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;	I-IV улиралд	-Дүн шинжилгээ, ажлын байрны зураглал хийсэн байх; - Үр дүнгээс хамааран хүнд суртал, чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх	Ажлын байрны зураглал хийх ажлыг зохион байгуулах	Institute of Public Monitoring нэртэй судалгааны байгууллагатай хамтран салбарын авлигын эрсдэлийн төсөөллийг судалгаа дараах хэлбэрийн оролцогчдоос авсан. Үүнд: 1. Уул уурхай, аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын бодлого боловсруулагч, бизнес эрхлэгчид, хувийн хэвшил, төрийн байгууллага, салбарт ажиллагсдын оролцуулан 2025 оны 09 дүгээр сарын 11-13-ны өдөр зохион

					байгуулагдсан “Mining Week” арга хэмжээний оролцогчид; 2. Төрийн болон хувийн хэвшилд ажиллаж буй болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд; 3. Байгууллагын бүх албан хаагчдаас 4. Эрдэс баялгийн салбарын хувийн хэвшлийг оролцуулах хүрээнд Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гишүүн байгууллагууд; 5. Уул уурхай, эрдэс баялгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуульч, өмгөөлөгч, судлаачид 6. “Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ зэрэг байгууллагын төлөөлөл; Уг судалгаагаар Аж үйлдвэр эрдэс баялагийн салбар дотроо Үндэсний геологийн албаны хариуцсан хэрэгжүүлж байгаа чиг үүрэг бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан. Тодоруулбал геологийн салбарын хувьд иргэдийн 30.5 хувь нь “бага эрсдэлтэй”, 38.6 хувь нь “дунд эрсдэлтэй”, 28.25 хувь нь “өндөр эрсдэлтэй”, 2.7 хувь нь “эрсдэлгүй” гэж үзсэн байна. Авлигатай тэмцэх газрын тандалт судалгааны баг 2025 оны 3 дугаар сард тус байгууллагад ажилласан бөгөөд багын бүрэлдэхүүнд ҮГА-ны эрх зүй, худалдан авалт, гадаад харилцаа, хүний нөөц, санхүүгийн чиглэлээр мэдээллийг гаргаж судалгаанд хамруулсан.
Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
13	Тухайн байгууллагын албан хаагчид албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг болон зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар нийт албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;	I-IV улиралд	Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	Сургалт зохион байгуулах	2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр АТГ-ын ажилтан, комиссар С.Баярцэцэг, А.Тунамал-Эрдэнэ нар тус байгууллагад хүрэлцэн ирж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэглээ, хэрэгжилтийн талаар болон авлигын гэмт хэрэг зөрчлийн шинжтэй үйлдлийн талаар сургалтыг зохион байгуулсан.

14	Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулах арга хэмжээ авах, санал асуулгын үр дүнд үндэслэн Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авах;	I-IV улиралд	Албан хаагчдыг санал асуулгад бүрэн хамруулсан байх; - АТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байх	Санал асуулгыг дотооддоо зохион байгуулах	2024 онд тус байгууллага Шударга байдлын үнэлгээгээр доогуур байр эзэлсэнтэй холбогдуулан АТГ-ын Байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүх албан хаагчдыг нууц санал асуулгад 2025 онд хамруулсан.
Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр					
15	Байгууллагын удирдах албан тушаалтан нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэсэн албан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, албан хаагчдаас гарсан авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах	I-IV улиралд	-Нийт албан хаагчдад шударга байдлын үнэлгээг сайжруулахад чиглэсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан байх	Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Байгууллагын удирдах албан тушаалтан, нийт албан хаагчдад шударга байдлын 2024 оны судалгаанд хамрагдсан эсэх талаар тодруулж үзэхэд тухайн онд манай байгууллагаас уг санал асуулгад оролцсон нэг ч албан хаагч байгаагүй бөгөөд "Бодлогын шийдэл" ТББ-аас судалгааг авах талаар ямар нэг албан бичиг ирүүлээгүй, судалгаа огт аваагүй, ямар нэг судлаач холбогдоогүй байтал МУ-ын хэмжээнд шударга байдлын үнэлгээгээр хамгийн муу үнэлэгдсэн дүн гарсан нь үндэслэлгүй гэж үзэхээр байна. Түүнчлэн 2024 онд албан тушаал дэвшүүлэх нэг ч томилгоо хийгээгүй, сул орон тоог бүрэн нөхөж чадахгүй байдалтай байсан байтал "Бодлогын шийдэл" ТББ-аас хийсэн гэх судалгаагаар манай байгууллага дотор албан тушаал дэвшиж томилогдоход гарын бэлэг сэлт өгөх байдал түгээмэл гэсэн дүгнэлт гарсан нь бодит байдалтай нийцэхгүй байна. Энэхүү эргэлзээтэй байдлыг тодруулах үүднээс Авлигатай тэмцэх газрын ажилтан комиссар А.Тунамал-Эрдэнэ-ээс google form-оор ирүүлсэн судалгаанд бүх албан хаагчдыг 2025 онд хамруулсан болно.